

АГУУЛГА

1. ЖОНШ БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	2
1.1. Түүхэн товчоон	2
1.2. Баяжуулах үйлдвэр	2
1.3. Хаягдлын аж ахуйн менежмент	4
1.4. Бүтээгдэхүүн үйлдвэрлэл.....	5
2. 2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	6
2.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт.....	6
2.2. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт	15
2.3. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт.....	16
2.4. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний биелэлт	19
2.5. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний биелэлт.....	19
2.6. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт	22
2.7. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт.....	27
2.8. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт.....	29
2.8.1. Агаарын тоосны хяналт шинжилгээ биелэлт	30
2.8.2. Хөрсний хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт.....	Error! Bookmark not defined.
2.8.3. Усны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт	29
2.9. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт	33
2.9.1. Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны арга хэмжээ	36
2.9.2. Удирдлага зохион байгуулалтын хүрээнд	37
2.9.3. Болзошгүй байгалийн аюул гамшиг.....	38
2.10. Аймаг, сумын орон нутгийн төрийн захиргааны байгууллагын шаардлагаар хийсэн ажил болон нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөөний биелэлт	41
ХАВСРАЛТ МАТЕРИАЛУУД	38
1. Төлбөрийн баримтууд.....	38
2. Шинжилгээний материалууд	45
3. Нөхөн сэргээлт хүлээн авсан акт	46


1. ЖОНШ БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

“Хөх бишрэлт” ХХК-ийн “Жонш баяжуулах үйлдвэр” нь Дорноговь аймгийн Иххэт сумын нутагт Монголросцветмет ХХК-ний ашиглаж байсан Хамар-Усны хайлуур жоншны ордын ил уурхайгаас олборлож гаргасан балансын бус жоншны хүдрийн овоолгыг түшиглэн жилд 150.0 мян.тн хүдэр боловсруулах хүчин чадалтайгаар 2017 онд баригдсан бөгөөд 2021 онд “Сити-Сүлжээ” ХХК-ийн Дэлгэр-3 нэртэй хайлуур жоншны орд, “Тайшаншин юань” ХХК-ийн Дай-Уул нэртэй хайлуур жоншны ордуудыг түшиглэж жилд бүрэн хүчин чадлаараа 300.0 мян.тн хүдэр боловсруулан баяжуулж, ФФ97 маркийн 76.3 мян.тн жоншны баяжмалыг гаргах хүчин чадалтайгаар ажиллахаар ТЭЗҮ /тодотгол/-ыг “Ерөтнцийн зүг” ХХК-иар боловсруулуулж Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Ашигт малтмал газрын тосны газрын Эрдэс баялагийн мэргэжлийн зөвлөлийн 2020 оны 11-р сарын 23-ны өдрийн Т/20-11-03 тоот дүгнэлтээр баталгаажуулжээ.

“Хөх бишрэлт” ХХК нь “Жонш баяжуулах үйлдвэр” төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланг 2017 онд “Ашид ананда” ХХК-иар хийлгүүлж, 2018 онд “Ашид ананда” ХХК-иар нэмэлт тодотголыг тус тус хийлгэсэн байна.

Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас 2021 оны 07-р сарын 09-ний өдөр “Хөх бишрэлт” ХХК-д өгсөн 13/3123 тоот “Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээний дүгнэлт”-ээр “Жонш баяжуулах үйлдвэр” төсөлд “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль”-ийн 7.3, Засгийн газрын “Журам батлах тухай” 2013 оны 374 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийх журам”-д заасны дагуу ерөнхий үнэлгээ хийсний үндсэн дээр байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийлгэх шаардлагатай гэж шийдвэрлэсэн байна.

“Хөх бишрэлт” ХХК-ийн “Цагаан Дэлийн жонш баяжуулах үйлдвэр” төсөл нь Дорноговь аймгийн Иххэт сумын нутагт, Улаанбаатар хотоос зүүн тийш 345 км, төмөр замын Бор-Өндөр өртөөнөөс зүүн тийш 50 км, Иххэт сумаас баруун тийш 5 км-т оршиж байна.



Зураг 1. Төслийн байршил

1.1. Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж байгууллагын товч мэдээлэл

Аж ахуйн нэгжийн нэр:	“Хөх Бишрэлт” ХХК
Аж ахуйн нэгж бүртгэлийн дугаар:	9019078088
Аж ахуйн нэгжийн харьяаллын хаяг:	Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг, 4 дүгээр хороо, Сайн ноён хан Намнансүрэнгийн гудамж, 35-3 тоот


1.2. Түүхэн товчоон

Үйлдвэр эхэлсэн огноо: “Хөх бишрэлт” ХХК нь Монгол улсад 2018 оноос хойш жонш баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагаагаа явуулж байна. Эзэмшигч нь Рэн Дэвэн, БНХАУ-ын 100%-ийн хөрөнгө оруулалттай үйлдвэр юм.


1.3. Баяжуулах үйлдвэр

Жоншны хүдэр боловсруулалтын технологийн процесс дараах схемийн дагуу явагдана. Үүнд:

- Хүдрийг 5.0 мян.м² талбайд овоолж дундажлах:
- Том бутлалтын хэсэг
- Дунд бутлалтын хэсэг (хяналтын шигшилттэй)
- Нунтаглалт (ангилалтын битүү циклээр ажиллах)
- Үндсэн флотаци, хяналтын флотаци, 6 үе шаттай цэвэрлэгээний флотаци,
- Баяжмалын өтгөрүүлэлт, шүүх, хатаах
- Хаягдлын аж ахуй зэрэг процессоос бүрдэнэ.



Зураг 2. Баяжуулах үйлдвэрийн технологийн схем



Зураг 3. Баяжуулах үйлдвэрийн тоног төхөөрөмжийн холболтын схем

1.4. Хаягдлын аж ахуйн менежмент

Хаягдлын сангийн /байгууламжийн/ зураг төсөл боловсруулах ажлыг “Ертөнцийн Зүг” ХХК-аар гүйцэтгүүлж, 2017 оны 6-р сарын 22-нд Улсын Экспертээр батлуулсан. Байгуулагдсан хаягдлын сан нь уул уурхайн хаягдлын санд ихэвчлэн хэрэглэгддэг бүхэлдээ 1.5 мм зузаан HDPE-High Density Polyethylene (Өндөр нягтралтай полиэтилен) геомембран доторлогоотой. Үйлдвэрээс хаягдлыг насосоор хаягдлын санд шахна. Хаягдлын санд хуримтлагдаж тунасан уснаас хөвөгч насосын системээр үйлдвэрт буцаан ус шахаж дахин ашиглах зохион байгуулалттай. HDPE хулдаас нь газрын хөрс, гадаргын болон гүний усыг баяжуулах үйлдвэрийн бохирдлоос хамгаалах бөгөөд хаягдлын сангийн дараах шаардлагыг бүрэн хангана. Үүнд:

- Баяжуулах үйлдвэрийн ашиглалтын хугацаанд гарах хаягдлыг багтаах хангалттай багтаамжтай ба нийт 562,316м³ эзэлхүүнтэй.
- Хүрээлэн буй байгаль орчин, олон нийтийн аюулгүй байдалд сөрөг нөлөөлөл үзүүлэхгүй
- Ашиглалтын үед болон хаалтын үед тогтвортой байдлаа хадгалах.
- Хаягдлын усыг эргүүлж ашиглах боломжтой
- Үерийн болзошгүй аюулаас хамгаалагдсан
- Хаягдлаас шүүрсэн ус гүний усанд нэвчихгүй байх нөхцлийг хангах, нэвчилт үүсэж буй эсэхийг хянах боломжтой
- Хаягдлын санг цаашид даланг өндөрсгөх замаар бүрэн ашиглах



Зураг 4. Хаягдлын сан

1.5. Бүтээгдэхүүн үйлдвэрлэл

Баяжуулах үйлдвэр нь 2022 оны 10 сарын 01-ний байдлаар 52.00 мян.тн хүдэр боловсруулан баяжуулж, 7.14 мян.тн ФФ95- ФФ97 маркийн бүтээгдэхүүн үйлдвэрлээд байна.

Хүснэгт 1. Баяжуулах үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл ба хаягдал

Бүтээгдэхүүн	2021 он	2022 оны 10 сар
Баяжмал	33,139	7,14
Хаягдал	198,831	44,86

2. БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДАЛ

2.1. Газрын гадаргын тогтоц ба онцлог

“Хөх бишрэлт” ХХК-ийн “Цагаан Дэлийн жонш баяжуулах үйлдвэр” төсөл нь Дорноговь аймгийн Иххэт сумын нутагт, Улаанбаатар хотоос зүүн тийш 345 км, төмөр замын Бор-Өндөр өртөөнөөс зүүн тийш 50 км, Иххэт сумаас баруун тийш 5 км-г оршиж байна. Төсөл хэрэгжих нутаг дэвсгэр болох Дорноговь аймгийн Иххэт сум нь Төв Азийн их цөл өндөрлөгийн умард хаяанд байрладаг. Төсөл хэрэгжих сумын нутаг дэвсгэр нь уул, гүвээ толгод бүхий заримдаг цөлийн бор саарал, цайвар бор, хужир мараат хөрстэй, хялгана, харганат цөлийн хээр алаг өвст ургамалтай, байгалийн хээржүү цөл хамаарна. Төсөл байрлах талбай нь Дорноговь аймгийн Иххэт сум нь далайн түвшнээс 937-1380 м өргөгдсөн байна.

2.2. Уур амьсгал

“Хөх Бишрэлт” ХХК-ийн Жонш баяжуулах үйлдвэр байрлах Дорноговь аймаг нь уур амьсгалын хувьд хуурайдуу сэрүүвтэр, хуурай дулаавтар мужид багтана. Манай орны бусад нутгийн нэгэн адил эх газрын эрс тэс уур амьсгалтай. Агаарын температурын үнэмлэхүй их агууриг 33.6 градус, өвөлдөө хүйтэх боловч зундаа аагим халуун болно.

Жилийн явцад агаарын темпаратурын хамгийн их утга нь 7 дугаар сард, бага утга нь өвөл 1 дугаар сард тус тус ажиглагддаг байна. Жилийн хамгийн дулаан 7 дугаар сарын дундаж агаарын темпаратур +22.1°C хамгийн хүйтэн 1 дугаар сарын дундаж агаарын темпаратур -19.1°C байна. Агаарын үнэмлэхүй хамгийн их темпаратур +33.5°C хүрч дулаарсан бол үнэмлэхүй хамгийн бага темпаратур -31.1°C хүрч хүйтэрсэн байна.

2.3. Гадаргын ус

Төсөл хэрэгжих нутаг дэвсгэр нь Умард говийн гүвээт Халхын дундад талын сав газарт хамаарна. Төслийн талбай орчим гадаргын усны сүлжээ муу хөгжсөн, төслийн талбайн ойр орчимд байнгын урсацтай гол горхи болон нуур байхгүй. Умард говийн усны сав газрын хүрээнд гадаргын усны нөөц хомс тул сав газар дахь жижиг нуур, тойром, гол горхиудад ус судлалын байнгын харуул бүхий ажиглалт, хэмжилтийн сүлжээ байхгүй. Сав газрын гадаргын усны сүлжээний нягтшил буюу 1 км² талбайд ногдох голын урт нь маш бага (0.01км/км²) бөгөөд сав газрын хэмжээнд хамгийн их урсац бүрдэлт нь сав газрын хойд, баруун хойд хэсэгт ажиглагдана.

2.4. Газрын доорх ус

“Хөх бишрэлт” ХХК-ийн хэрэгжүүлж буй “Жонш баяжуулах үйлдвэр” төсөл байрлах нутаг дэвсгэр нь Умард говийн гүвээт халхын дундад талын сав газарт хамаарах ба энэхүү сав газрын гидрогеологийн нөхцлийн гол онцлог нь төв азийн гадагш урсгалгүй ай савд багтах, ихэнх нөхцөлд хоорондоо нарийн хүзүүвчүүдээр холбогдсон, олон төрлийн ус агуулагч үе, давхарга, бүрдэл, ан цавын усжсан бүс бүхий газрын доорх усны сав газар юм. Газрын доорх усны тэжээгдлийн бүс нь янз бүрийн насны өгөршил, тектоникийн хагарал, эвдрэл, ан цавшилт эрчимтэй өртсөн түрмэл (интрузив), бялхмал, тунамал, хувирмал үндсэн чулуулгаас зонхилж тогтсон байна.

Газрын доорх усны хуримтлал болон хөлийн бүс нь дөрөвдэгч, голоцены настай аллюви, пролюви, нуур, салхины гаралтай сэвсгэр хурдасны зузаалаг, дахь уст үе, давхарга, неоген, палеоген, цэрдийн настай тунамал хурдасны зузаалаг дахь нүх сав-давхраасын уст давхарга,

бүрдэл, юра, триас, пермийн настай эх газрын гарал үүсэлтэй чулуулгийн зузаалаг дахь ан цавын усжсан бүсээс бүрдсэн хөндий, хотгор, хоолой зэрэг нам доор газрууд хамрагдана.

Газрын доорх усны хөдөлгөөний ерөнхий зүй тогтол нь өндөрлөг хэсгээсээ нам дор газар луугаа чиглэх ба бага зузаантай дөрөвдэгчийн настай сэвсгэр хурдас нь өөрийнхөө доор байрлах бусад ус агуулагч давхарга руу газрын доорх усыг нэвтрүүлэх үүргийг гүйцэтгэдэг. Сав газрын өндөрлөг хэсгүүдээр тархсан үндсэн чулуулгийн массивын гадаргуу орчимд ихэвчлэн экзогений гарал үүсэлтэй харьцангуй жигд бус, эмх замбараагүй тархалттай ан цавшилын бүс үүссэн байдаг. Эдгээр ан цавын бүсэд газрын доорх ус тодорхой хэмжээгээр хуримтлагдах боломжтой боловч биеэ даасан уст давхарга ховор ихэвчлэн тэжээлийн гадаад мужийн үүргийг гүйцэтгэнэ.

2.5. Хөрсөн бүрхэвч

Төслийн талбайд хамаарах газар нь 1230-1260 метрийн үнэмлэхүй өндөртэй нам уулс болон гүвээрхэг тэгшивтэр талархаг газарт байрлана. Төслийн талбайд тархсан хөрсөн бүрхэвч нь Монгол орны хөрс- газарзүйн мужлалтаар хархүрэн, хүрэн хөрс зонхилон тархсан Бор өндөр уул баяны тойрогт хамрагддаг. Энд өргөрөгийн бүсийн зүй тогтолтой уялдан хүрэн хөрс бөгөөд эзэмшил талбайн зүүн хэсэг дэх сайрын гольдролд ул хөрсний усны түвшин, эрдэсжилтээс хамаарч сайрын сул хөгжилтэй хөрс багахан газарт тархдаг.

2.6. Ургамлан нөмрөг

Төслийн талбай нь ургамал-газарзүйн тойргоор Дундаж Халхын хээрийн тойрогт байрлах боловч Дорно-Говийн цөлөрхөг хээрийн тойрогт шилжих хил залгаа бүс нутагт байрлаж байна. Энд хойноосоо Дундад халхын хээрийн үет ургамлын төлөөлөл өмнөөсөө цөлөрхөг хээрийн жижиг сөөг сөөгөнцөр ургамлын төлөөлөл тохиолдох онцлогтой. Төслийн талбай нь Монголын төв хэсгийн боржин бүхий бэсрэг уулс, ухаа гүвээрхэг толгод хоорондын нарийн хотос хоолойд байрлаж байна.

Ерөнхийдөө төслийн талбай орчим нь толгодорхог хэсгээр харгана-үетэн ургамлан бүлгэмдэл харин нам хотос, хажуу хэсгээр харгана-үетэн-алаг өвст, гэсэн 2 үндсэн ургамлан бүлгэмдэл тохиолдож байна. Уг ургамлан бүлгэмдлүүдийг дагаж, Гялгар дэрс (*Achnatherum splendens*), Хазааргана (*Cleistogenes squarrosa*), Ширэг улалж (*Carex duriuscula*), Крылов хялгана (*Stipa Krilovi*), Агь (*Artemisia frigida* Willd), Имт гичгэнэ (*Potentilla bifurca*), Ишгүй гичгэнэ (*Potentilla acaulis*), Жижиг навчит харгана (*Garagana micropylla*), Нарийн навчит харгана (*Caragana stenophylla*), Манан хамхаг (*Bassia dasyphylla*), Аммоны сэдэргэнэ (*Convolus ammoni*), Бага хургалж (*Eragrostis minor*) Шүлхий Шарилж (*Artemisia pectinata*), зэрэг ургамлууд зонхилгогч болон дэд зонхилгогчоор ургана.

2.7. Амьтны аймаг

Төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн орчинд хуурай хээр болон хуурайдуу хээрийн экосистем тархсан.

Амьтны аймгийн хувьд цагаан зээр, үлийн цагаан оготно, монгол чичүүл, монгол тарвага, хярс, мануул, идлэг шонхор, хээрийн бүргэд, шилийн сар, монгол болжмор зэрэг хөхтөн болон шувууд төлөөлөх зүйлд тооцогдоно.

Хөхтөн амьтан: Төслийн талбай орчим Монгол улсын улаан данс (2006)-ны ховордлын зэргийн үнэлгээгээр “устаж болзошгүй” зүйлийн ангилалд бүртгэгдсэн 1 зүйл, “эмзэг” 1 зүйл,

“ховордож болзошгүй” 5 зүйл хөхтөн амьтан тус тус оршин амьдарч байна. Нөгөө талаас “мэдээлэл дутмаг” ангилалд бүртгэгдсэн 5 зүйл хөхтөн амьтад байна.

Мөлхөгчид: Мөлхөгчдөөс энэ бүс нутагт 3 овог, 3 төрөлд хамаарах 3 зүйл тархдаг ажээ. Энд тархсан гүрвэл болон могойн зүйлүүд нь Монгол орны хэмжээнд түгээмэл тархацтай юм. Мөлхөгч амьтдын хувьд газрын тос олборлолт, хайгуулын үед хөнөөгдөх эрсдэл харьцангуй бага бөгөөд энэ талбайд тоо толгойн хувьд элбэг, тархацын хувьд түгээмэл амьтад тархсан байна.

Шувуу: Төслийн талбай орчим 123 зүйлийн шувуу тохиох боломжтой ба тус бүс нутагт хээрийн шувууд зонхилон тархсан байдаг. Шувууны аймгийн хувьд зусаж өндөглөдөг ба хэсэгчлэн нүүдэг шувууд зонхилох (103 зүйл) бөгөөд жилийн турш суурин амьдардаг 19 зүйл, зөвхөн өвөл ирээд буцдаг цөөн шувуу (1 зүйл) байна.

3. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Төслөөс байгаль орчны бүрдэл хэсгүүд болох газрын гадарга, хэвлий, гадаргын болон газрын доорх ус, хөрс, ургамал зэрэгт үзүүлэх болзошгүй сөрөг нөлөөллүүдийг БОННУ-ний тодотгол тайланд нарийвчлан тусгаж, тэдгээрийг бууруулах, сэргийлэх, арилгах арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулсан байдаг.

3.1. Газрын гадарга ба хэвлий

Төслийн үйл ажиллагаанаас газрын гадарга, хэвлийд үзүүлэх болзошгүй болон зайлшгүй сөрөг нөлөөллүүдийг товч дурдвал:

- Барилгажилт, дэд бүтэц барьж байгуулах болон баяжуулах үйлдвэрийн ашиглалтын үйл ажиллагааны улмаас газрын гадарга, хэвлийн хэлбэр дүрс өөрчлөгдөх
- Төслийн үйл ажиллагааны улмаас хаягдлын талбай, овоолгын талбай тэлэх, барилга байгууламжууд нэмж байгуулах, шинээр зам гаргах.

3.2. Агаарын чанар

Жигдрүүлсэн хүдрийг бункерт тэжээх, 3 шатны бутлуураар бутлах, шигших, хүдэр хадгалах талбайд туузан дамжуулгаар буулгах зэрэг бүхий л шат дамжлагуудаас тоос тоосонцор үүсдэг. Мөн идэвхтэй овоолго, эвдрэлд орсон талбай зэргээс хуурай салхитай үед тоос шороо агаарт дэгдэж салхины дагуу тархах зэрэг нь төслийн үйл ажиллагаанаас агаарт үзүүлэх сөрөг нөлөөлөл болж болзошгүй юм.

3.3. Хөрсөн бүрхэвч, гадаргын болон гүний ус

Төслийн үйл ажиллагаанаас гадаргын болон гүний усанд үзүүлэх гол болон болзошгүй нөлөөлөл нь хаягдлын далан болон химийн бодисын агуулхаас бохирдуулагч бодис алдах, шатах тослох материал, хатуу болон шингэн хог хаягдлын талбайгаас бохирдол үүсэх зэрэг юм.

Төслийн үйл ажиллагаанаас хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөлөл нь шинээр шимт хөрсний хуулалт хийгдэх газарт үүсэх хөрсний эвдрэл ба бүтэцийн алдагдал, үйлдвэрийн дотоод замаар зорчих техникийн нөлөөгөөр үүсэх өнгөн хөрсний талхагдал, төслийн талбайгаас үүсэх тоосонцорын тархалт гэсэн өдөр тутамд үүсч байгаа сөрөг нөлөөллөөс гадна авто зогсоол ба засвар үйлчилгээний талбай орчимд үүсэх шатах тослох материалын цэгэн бохирдол, ахуйн гаралтай органик ба хатуу, шингэн хог хаягдлаас үүдэлтэй механик болон нянгийн бохирдол гэсэн болзошгүй сөрөг нөлөөллүүд байна.

3.4. Ургамлан нөмрөг, амьтны аймаг

Жонш баяжуулах үйлдвэрийн 2022 онд хийгдсэн БОННУ-ний тодотгол тайланд төслийн талбай орчим Монгол улсын улаан данс (2006)-ны ховордлын зэргийн үнэлгээгээр “устаж болзошгүй” зүйлийн ангилалд бүртгэгдсэн 1 зүйл, “эмзэг” 1 зүйл, “ховордож болзошгүй” 5 зүйл хөхтөн амьтан тус тус оршин амьдарч байгаа талаар тусгасан байдаг. Төслийн үйл ажиллагаанаас амьтны аймагт үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл нь дуу чимээнээс амьтад дайжих, зам, дэд бүтэц байгуулснаас үүдэн амьдрах орчин алдагдах зэрэг болно.

Харин ургамлан нөмрөгт үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл нь дэд бүтэц, барилга, бүтээн байгуулалтын үйл ажиллагаанаас үүдэн ургамлан нөмрөг талхлагдах юм.

4. 2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

“Хөх Бишрэлт” ХХК нь жонш баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагаа явагдах газар нутгийн байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг боломжит хамгийн бага түвшинд байлгах, байгаль орчинд үзүүлэх аливаа сөрөг нөлөөллөөс зайлсхийх, урьдчилан сэргийлэх, нөхөн сэргээх, дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэн талуудын оролцоог хангасан хууль эрх зүйн шаардлагад нийцүүлэн гүйцэтгэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг нөлөөллийн үр дагаврыг тогтмол хянах, илрүүлэх, хяналт шинжилгээний хөтөлбөрийг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлж мөн нутгийн иргэдийн оролцоог хангах, нэмэгдүүлэх зорилт тавьж байна.

Бид 2022 онд Үйлдвэрийн Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний судалгаагаар тогтоогдсон гол болон болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ, тухайн жилийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэн ажиллаж байна,

Үйлдвэрийн 2022 оны “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө”-ний гол зорилт нь жонш баяжуулалтын үйл ажиллагаа, химийн бодис тээвэрлэх, хадгалах болон ашиглах, хог хаягдлыг түр хадгалах, тээвэрлэх зэрэг үйл ажиллагааны улмаас байгаль орчинд учирч болзошгүй сөрөг нөлөөллөөс зайлсхийх, урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ тэдгээрийг хэрэгжүүлэх зардал, баримтлах хууль эрх зүйн орчныг тодорхойлох, мөн байгаль орчинд учирч болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд оршино.

Бид 2022 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахдаа Монгол улсын “Байгаль орчныг хамгаалах тухай” болон “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуулиуд, 2019 онд Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын А/618 тоот тушаалаар баталсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”, Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээний дүгнэлт, мөн нарийвчилсан үнэлгээний үр дүн зэргийг удирдлага болгож, үйлдвэрийн үйл ажиллагаатай уялдуулан төлөвлөсөн болно.

Бид үйлдвэрийн үйл ажиллагаанаас хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг байж болох хамгийн бага хэмжээнд байлгах бөгөөд байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хамрах хүрээ нь тусгай зөвшөөрөлтэй талбай, түүнээс гадна ОХШХ-т багтсан хяналт шинжилгээний цэгүүд хамаарна.

4.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10-р сарын 29-ны өдрийн А/618 тушаалаар баталсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”, “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө” боловсруулах зөвлөмжийн дагуу уурхай, үйлдвэрийн үйл ажиллагаанаас үүсэх гол болон болзошгүй сөрөг нөлөөллийг өртөх орчноор буюу байгаль орчны бүрэлдэхүүн хэсэгт хуваасан. Тус бүрэлдэхүүн хэсэг болох агаар, хөрс, гадаргын ба газрын доорх ус, амьтан, ургамал, газрын хэвлийд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах зэрэг чиглэлүүдээр бүлэглэн 2022 оны сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулсан.

БОННУ-нд тодорхойлсон байгаль орчны бүрдэл хэсгүүдэд үзүүлэх сөрөг нөлөөлөл мөн үйлдвэрийн 2022 оны үйл ажиллагаатай уялдуулан гол болон болзошгүй 7 сөрөг нөлөөллийг тодорхойлж, тэдгээрийг бууруулах, сэргийлэх, арилгах 15 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.

Тайлант онд Бид болзошгүй 7 сөрөг нөлөөллийг тодорхойлж, тэдгээрийг бууруулах, сэргийлэх, арилгах 15 арга хэмжээ төлөвлөж 13 ажлыг хэрэгжүүлсэн (тогтмол хийгддэг үргэлжилж буй ажлыг хэрэгжүүлсэнээр тооцов) бөгөөд 1 ажил явцын шатандаа явж байна. Мөн 1 ажил хугацааны хувьд хэрэгжих болоогүй ажил болно. Тус төлөвлөгөөний хэрэгжилт компанийн дотоод дүгнэлтээр 93.3 хувь байна. Биелэлтийн дэлгэрэнгүй мэдээллийг доорх хүснэгтээс харна уу.

Хүснэгт 2. Хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл		Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Биелэлт	Тэмдэглэл
	БО бүрдэл хэсэг	Сөрөг нөлөөлөл			
1	Агаар	Үйлдвэрлэлийн үйл ажиллагаа, автомашин, техникүүдээс гарах тоосжилт нь агаарын чанарт нөлөөлөх	Замын гадаргыг шаардлагатай хэсгүүдэд засах, усалгааг хийх	100%	Үйлдвэрийн талбайн дотоод автозамын усалгааг дулааны улиралд сард 10 удаа, хүйтний улиралд шаардлагатай тохиолдолд хийж байна. 2022 оны эхний 10 сарын байдлаар цооногийн гүний худгаас 180 куб метр усыг авто замын усалгаанд ашигласан байна.
2			Агаарын чанарын багаж суурилуулах, хяналт тавих	30%	Агаарын чанарын багаж суурилуулахаар судалж байгаа бөгөөд үйлдвэрт тохирох багаж олж, худалдан авалт хийхээр ажиллаж байна. Тус ажлыг 2023 онд бүрэн хэрэгжүүлж дуусахаар төлөвлөж байна.
3			Үйлдвэрийн орчны авто замын хурдны хязгаарлалтыг заасан тэмдэгжүүлэлтийг нэмэх, сайжруулах	100%	Үйлдвэрийн талбай доторх замуудад хурдны хязгаар тогтоосон (5,10 км/цаг) тэмдэг, тэмдэглэгээнүүдийг байршуулсан.

4			Тээврийн хэрэгслийн ашиглалт, техникийн байдалд хяналтын үзлэг, системүүдийн техникийн байдлыг оношлуулах, шаардлагатай бол засвар тохиргоог хийлгэх	100%	Тээврийн хэрэгслүүдэд 5000, 8000, 20000 км тутамд тос солих болон шаардлагатай үйлчилгээнүүдийг хийдэг. Үүнээс гадна мөн улирлын болон жил тутмын улсын техникийн үзлэг оношлогоог байнга хийлгэдэг.
5	Хөрс	Шатах тослох материалын асгаралтаас хөрс бохирдох	Шатах тослох материал, химийн бодисын хадгалалтанд хяналт тавих	100%	Тос тосолгооны ажил хийх үед хөрс бохирдохоос урьдчилан сэргийлж зориулалтын зассан талбайд тос тосолгооны ажлыг хийдэг, хөрсөнд шатах тослох материал алдагдахаас сэргийлж гэмтэл, эвдрэлтэй машин, техникийг ажлын талбайд гаргахгүй байх зарчмыг баримтлан ажиллаж байна.
6		Олон салаа шороон зам, далангаас хөрсний бүтцэд өөрчлөлт орох	Тээвэрлэлтийн олон салаа зам гарахаас сэргийлж дотоод, гадаад замын 2 талаар хязгаарлах далан тэмдэг тэмдэглэгээ хийх	100%	Үйлдвэрийн талбай доторх автозамуудад хурдны хязгаар тогтоосон (10км/цаг) тэмдэг болон бусад тэмдэгнүүдийг байршуулсан. (зураг-4)
7	Гадаргын ба газрын доорхи усны нөөц	Гадаргын ба газрын доорхи усны нөөц багасах	Гүний худгийн эрүүл ахуйн хамгаалалтын бүс тогтоож, тэмдэгжүүлэх, хамгаалах, эрүүл ахуйн бүсэд мөрдөх дэглэмийн хэрэгжилтийг хангаж ажиллах	100%	Хөх Бишрэлт ХХК нь үйл ажиллагаа явуулж буй бүс нутгийн усны нөөц, чанарт учирч болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах, усыг дахин ашиглах, усны нөөц, чанарыг хэвээр хадгалахыг зорьж ажилладаг. Компанийн эзэмшлийн худгуудын тоолуурыг холбогдох хууль, дүрэм журмын дагуу мэргэжлийн байгууллагаар баталгаажуулсан бөгөөд худгийг тоноглон хамгаалж, ундны усны эрүүл ахуйн шаардлагад нийцүүлсэн.
8			Жонш боловсруулалтын ажлын явцад орчны тоосжилтыг бууруулахад газар доорх усны нөөцийг аль болох ашиглахаас зайлсхийж, цэвэршүүлсэн ахуйн хаягдал усыг эргүүлж ашиглах боломжийг судлах, боломжтой бол ашиглах.	100%	Бид 2022 онд 684 м3 усыг унд ахуйд хэрэглэсэн байна. Унд ахуйд хэрэглэсэн бохир усыг цэвэрлэх байгууламж, төхөөрөмжөөр 98% хүртэл цэвэрлэж газрын хөрсөнд шууд шингээдэг. Цаашид саарал усыг дахин ашиглах боломжийг судалж байгаа бөгөөд хэрвээ боломжтой тохиолдолд 2023 оноос эхлэн зам талбайн усалгаанд ашиглахаар төлөвлөж байна.

9			Худгуудын тоолуурын ажиллагаа болон усны ашиглалтад хяналт тавьж бүртгэл хөтлөх, /ус ашиглах зөвшөөрөл, гэрээнд заасан хэмжээнээс хэтрүүлэн ашиглахгүй байхад хяналт тавина/	100%	Ус ашиглалтад хяналт тавьж бүртгэлжүүлэн ус ашиглах, мөн бохир усны дүгнэлтийг жил бүр гаргуулан үйл ажиллагаандаа хэвшүүлсэн.
10			Бэлчээрийн усан хангамжийг сайжруулах, Дэлхийн усны өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх зэрэг арга хэмжээнд Сумын тамгын газартай хамтарч ажиллах, санхүүгийн дэмжлэг үзүүлэх	100%	Сум орон нутагтай байнгын харьцаатай хамтран ажиллаж санхүүгийн дэмжлэг үзүүлдэг
11			Ургамал талхлагдсан хэсгээр өөр төрлийн ургамалжуулалт хийх	100%	Талхлагдсан хэсгийг ургамалжуулах ажлыг эхлүүлсэн
12			Тэрбум мод хөдөлгөөнд идэвхи санаачилгатай оролцож, мод тарих усалгаажуулах	100%	Тайлант жилд 5 сая төгрөгний үнэ бүхий гацуур модны суулгац худалдан авч Иххэт сумын ЗДТГ-г хүлээлгэн өгсөн.
13	Ургамлан нөмрөг	Ургамал талхлагдах ургамлын нөмрөг доройтох	Шимт хөрсний агрохимийн шинжилгээг хийлгэх, хадгалалтыг сайжруулах, салхинд хийсэхээс хамгаалж гадаргын хэсгийг ургамалжуулах	100%	Шимт хөрсний арчилгаа, тордолтыг тогтмол хийж гүйцэтгэж байна. Шимт хөрсний овоолгыг салхинд хийсэх, усанд автах, хужиртах, хатуу биет, чулуу, барилгын болон бусад хаягдалд дарагдаж бохирдохоос хамгаалах, урьдчилан сэргийлэх ажлыг хэрэгжүүлсэн. Мөн шимт хөрсний хадгалалт, хамгаалалт, тордолтын бүртгэлийг тогтмол хийж хяналт тавин ажиллаж байна.
14	Амьтны аймаг	Жигүүртэн шувууд өртөх	ЦДАШ-д шувуу үргээгч суурилуулах	70%	Энэхүү ажил хэрэгжиж байгаа бөгөөд бүрэн хэрэгжиж дуусаагүй болно. 2023 онд тус ажлыг бүрэн хэрэгжүүлж дуусгахаар төлөвлөн ажиллаж байна.
15		Мал амьтан өртөх	Гадна тээврийн замд мал амьтны шилжилт нүүдэл өнгөрөх магадлалтай хэсэгт тэмдэг тэмдэглэгээ байрлуулах	100%	Гадна тээврийн замд мал амьтан гарч болзошгүй хэсэгт холбогдох тэмдэг тэмдэглэгээг байршуулсан
СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ 2022 ОНЫ БИЕЛЭЛТ				93.3%	



Зураг 5. Замын тэмдэг тэмдэглэгээ



Зураг 6. Гүний худаг, тоолуурын баталгаажуулт

4.2. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт



Зураг 7. Нийтийн их цэвэрлэгээ



Зураг-8. Хүдрийн овоолго



Зураг 9. Даланг өндөрлөсөн байдал

Хүснэгт 3. Нөхөн сэргээлтийн ажлын хэрэгжилтийн биелэлт

№	Нөхөн сэргээлтийн зорилт	Хэрэгжилт	Биелэлт	Тайлбар
1	Техникийн нөхөн сэргээлт	Тогтмол хэрэгжүүлж байна	100%	Орчноо хог хаядалгүй цэвэр байлгах зорилгоор бүх ажилчдыг хамруулан, талбайн их цэвэрлэгээг тодорхой хуваарийн дагуу зохион байгуулж ажиллаж байна.
			100%	2019 оноос овоолгын хэлбэржүүлэлтийн ажлыг хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд одоо тогтмол хийгдэж байна.
2	Биологийн нөхөн сэргээлт		100%	Тайлант онд нийт 1 га-д 10,000 м ³ эзлэхүүнтэй газарт техникийн нөхөн сэргээлт явуулсан. Иххэт сумын Баян багийн төв, хуучнаар Иххэт сумын төв оршиж байсан газрын туурийг цэвэрлэж, тухайн газарт техникийн нөхөн сэргээлтийн ажлыг тус тус хийж гүйцэтгэсэн.
НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ 2022 ОНЫ БИЕЛЭЛТ			100%	

4.3. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Хөх Бишрэлт ХХК нь Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн холбогдох заалтууд, Засгийн газрын 2013 оны 374 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт, Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журмын 5.2, 5.3 дах заалтууд болон 2014 оны БОНХ-ийн сайдын А-117 тоот тушаалын 2 дугаар хавсралт “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний аргачлал”-ын 3.3.6-д тус тус заасны дагуу Биологийн олон янз байдлыг (БОЯБ) дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Төслийн БОННУ тодотгол тайланг "ЕАСС" ХХК 2022 онд хийж гүйцэтгэсэн ба үүнд дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө, зардал, боломжит хувилбарууд зэргийг тооцсон байдаг. Энэхүү тооцооллын хүрээнд Хөх Бишрэлт ХХК-ний Жонш баяжуулах үйлдвэр төслийн үйл ажиллагаанаас нийт 561 га талбайг дүйцүүлэн хамгаалах шаардлагатай гэж тооцсон байдаг.

Манай компани нь дүйцүүлэн хамгаалах хэмжээний хүрээнд төслийн БОННУ-ний тодотголд тусгагдсаны дагуу тайлант онд нийт 1 га-д 10,000 м³ эзлэхүүнтэй газарт техникийн нөхөн сэргээлт хийж явуулсан. Тус газар нь Иххэт сумын Баян багийн төв, хуучнаар Иххэт сумын төв оршиж байсан газар бөгөөд туурийг цэвэрлэж, тухайн газарт техникийн нөхөн сэргээлтийн ажлыг Монгол улсын холбогдор стандартын дагуу бүрэн хийж гүйцэтгэсэн.



Зураг 10. Нөхөн сэргээлт хийсэн талбайн байршил, координат

Үүсэн хоосон орон зайг дотоод овоолгоор дүүргэн “Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт” MNS 5917:2008 стандартын шаардлагын дагуу газрын гадаргын хэлбэржүүлэлтийг хийж, биологийн нөхөн сэргээлтэд бэлэн болгож орон нутагт хүлээлгэж өгсөн. /Нөхөн сэргээлт хүлээлгэж өгсөн актыг хавсралтад оруулав.



Зураг 11. Нөхөн сэргээлт хийхээс өмнөх байдал



Зураг 12. Нөхөн сэргээлт хийж буй үе



Зураг 13. Нөхөн сэргээлтийн дараах байдал

НӨХӨН СЭРГЭЭЛТ ХИЙСЭН ДҮГНЭЛТ:

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 5 дугаар хэсгийн 5.1.8-д “Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрч, олон жил орхигдсон талбайг нөхөн сэргээх” заасан зорилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Монгол Улсын Шадар сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Уул уурхай хүнд үйлдвэрийн сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд нарын хамтарсан ТУШААЛ “Нэгдсэн арга хэмжээг зохион байгуулах тухай” 2020 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн №167, А/698, А/336, А/242 дугаартай тушаал, аймгийн Засаг дарга Тамгын газрын ХОХБТХ-ийн даргын 2021 оны 03 дугаар сарын 05-ны өдөр уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрч доройтсон талбайг нөхөн сэргээх “Нөхөн сэргээлт-2024” арга хэмжээний төлөвлөгөө хэрэгжүүлэн ажилласан.

Нөхөн сэргээх ажлыг 2021 оны 04 дугаартай гүйцэтгэх гэрээ сумын Засаг даргын Тамгын газрын даргатай “Хөх бишрэлт” ХХК байгуулсан.

“Хөх бишрэлт” ХХК нь “Нөхөн сэргээлт-2024” нэгдсэн арга хэмжээний хүрээнд хуучин Иххэт сумын төв одоогийн Баян багийн төвийн барилга байгууламжийн суурь, туурь, хог хаягдлыг цэвэрлэх, техникийн нөхөн сэргээлтийн ажлыг хийж гүйцэтгэх гэрээ байгуулж, байгаль орчныг хамгаалах болон нийгмийн өмнө хүлээсэн хариуцлагын хүрээнд нөхөн сэргээлтийн ажлыг зохион байгуулж өөрсдийн хөрөнгө, техник тоног төхөөрөмжийг ашиглан, техникийн нөхөн сэргээлтийн ажлыг нийт 1 га талбайд 15,0 сая төгрөгний зардал гаргаж гүйцэтгэсэн тул сумын комисс актаар хүлээн авав.

Техникийн нөхөн сэргээлтийг цаг хугацаанд нь стандартын дагуу чанартай, үр дүнтэй хийж гүйцэтгэсэн гэж дүгнэж, фото зургаар баримтжуулж, акт үйлдэв.

АКТ ГАРГАСАН:

Комиссын дарга: Байгаль орчны бодлогын мэргэжилтэн М.Ганбат.
Гишүүд: Сумын орлогч дарга Ц.Золзаяа
Газрын даамал: Г.Батсүх
Баян багийн Засаг дарга Б.Содмагнай
Иргэний төлөөлөл: Баян багийн малчин Т.Гангэрэл

ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРСӨН:

“Хөх бишрэлт” ХХК-ний баяжуулах үйлдвэрийн дарга /Ц.Ариунцэцэг/

Байгаль орчин,ногоон хөгжил,аялал
жуулчлалын Сайдын 2015 оны 12
сарын 16-ны өдрийн А/419 тоот тушаал

Нөхөн сэргээлт хийсэн газрыг хүлээж авах акт

2022 оны 10 дугаар сарын 14-ний өдөр

№	Асуулт	Хариулалт
1	Байршил	Монгол Улс
	Аймаг,нийслэл:сум,дүүрэг: баг,хороо:	Дорноговь аймгийн Иххэт сумын Баян баг
	Газрын нэр:	Баян багийн төв Олон байшинт нэртэй газарт.
2	Аж ахуйн нэгжийн нэр	“Хөх бишрэлт” ХХК
	Хаяг:	
	Аж ахуйн нэгжийн гэрчилгээний дугаар:	9019078088
	Регистр:	5878756
3	Тусгай зөвшөөрлийн дугаар:	Хуучин Иххэт сумын төв одоогийн Баян багийн төвд эвдэрсэн барилга байгууламжийн суурь, туурь, хог хаягдлыг цэвэрлэж нөхөн сэргээж хүлээлгэн өгөх.
	Ордын нэр:	-
	Талбай /га-аар/:	46° 14' 48,63" 110° 10' 2,40"
		46° 14' 52,56" 110° 10' 2,33" 46° 14' 52,60" 110° 10' 6,98" 46° 14' 48,64" 110° 10' 5,71"
4	Орон нутагт нөхөн сэргээлт хүлээлгэн өгсөн албан тушаалтан: Овог нэр: Утас:	“Хөх бишрэлт” ХХК-ний баяжуулах үйлдвэрийн дарга Цогзол Ариунцэцэг 99153477
5	Нөхөн сэргээлтийн ажлыг газар дээр нь хэмжиж зураглал үйлдсэн мэргэжлийн байгууллагын нэр: Хаяг:	Сумын ЗДТГазрын Газрын даамал: Г.Батсүх Дорноговь аймгийн Иххэт сум Засаг даргын Тамгын газар
Нөхөн сэргээлтийн хэмжээ, чанар, үр дүн		
6	Нөхөн сэргээлтийн хэмжээ	
	1.Техникийн нөхөн сэргээлт	Техникийн нөхөн сэргээлт
	Талбайн хэмжээ /га-аар/	1 га
	Хийсэн ажлын хэмжээ /мян м3/	10000м3
	Зардал /төгрөгөөр/	15000000 / арван таван сая төгрөг/
	2.Биологийн нөхөн сэргээлт	-
	Талбайн хэмжээ /га-аар/	-
Тарьсан мод ургамал / төрлөөр/	-	
	Зардал /төгрөгөөр/	-
7	Дүйцүүлэн хамгаалах чиглэлээр гүйцэтгэсэн ажлын танилцуулга, үр дүн	Дээрхи талбайд нөхөн сэргээлтийн ажлыг цаг хугацаанд нь стандартын дагуу чанартай сайн гүйцэтгэсэн гэж дүгнэж акт үйлдэв.
8	Нэмэлт мэдээлэл 1:2000 масштабтай зураглал,шинжилгээний дүн,фото зураг,хүлээлгэн өгсөний дараа хийх хяналт мониторингийн зардалтай холбоотой баримт материалыг хавсаргаж болно.	Сумын ЗДТГазартай нөхөн сэргээх ажлыг 2021 оны 04 дугаартай гүйцэтгэх гэрээ байгуулсан. Гүйцэтгэсэн ажлын эхэн үе болон гүйцэтгэж буй гүйцэтгэсны дараа үеийг фото зургаар зурагжуулсан.

4.4. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний биелэлт

Үйлдвэрийн нөлөөллийн бүсэд хамрагдаж байсан нэг өрхөд нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох, тусламж үзүүлэх санал албан ёсоор гаргасан. Гэвч тухайн өрх саналыг хүлээн аваагүй бөгөөд үйлдвэрийн нөлөөллийн бүсээс нүүсэн. Иймд үйлдвэрийн нөлөөллийн бүсэд орших нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ хэрэгжүүлэх шаардлагатай өрх байхгүй болно.

Хүснэгт 4. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний биелэлт

№	Гүйцэтгэх ажил	Биелэлт	Тайлбар
1	Төлөвлөгдөөгүй	100%	Үйлдвэрийн нөлөөллийн бүсэд орших нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ хэрэгжүүлэх шаардлагатай өрх байхгүй болно.

4.5. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний биелэлт

Бид 2022 оны БОМТ-ний түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөнд Иххэт сумын биет болон биет бус өвийг хамгаалах 2 арга хэмжээ төлөвлөн хэрэгжилтийг хангаж ажиллалаа. Энэхүү арга хэмжээнүүд нь түүх, соёлын өв болон түүний хамгааллын тухай мэдээлэл хүргэх, аливаа үйл ажиллагааны явцад түүх, соёлын өв илэрсэн тохиолдолд авах арга хэмжээг тодорхойлох зорилготой байсан болно.

Хүснэгт 5. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний биелэлт

№	Нөлөөлөлд өртөх түүх, соёлын өв	Хамгаалах арга хэмжээ	Биелэлтийн хувь	Биелэлтийн тайлбар
1	Биет өв	Үйлдвэрийн үйл ажиллагааны үед архелогийн болон палеонтологийн ховор түүхийн дурсгалт олдворууд гарч ирж болзошгүй. Энэ тохиолдолд заавал төрийн холбогдох байгууллагуудад мэдэгдэх	-	Төслийн хэрэгжилтийн явцад ямарваа нэгэн түүх соёлын дурсгалт зүйл олдоогүй болно.
2	Биет бус өв	Сум орон нутгийн хэмжээнд соёлын биет бус өвийг хамгаалах, биет бус өвийг өвлөн уламжлагчийг урамшуулах, түгээн дэлгэрүүлэх зорилготой зохион байгуулж буй үйл ажиллагаанд дэмжлэг туслалцаа үзүүлэх	100%	Компанийн хүрээнд хэрэгждэг сарын сэдэвчилсэн аяны хүрээнд “Соёлын өвийг дээдлэгч” аяныг зохион байгуулж нийт ажилчдад мэдээлэл бэлтгэн байршуулсан. Энэхүү аяны хүрээнд бид Монгол Улсын, тэр дундаа бидний үйл ажиллагаа явуулж буй говь нутгийн соёлын өв дурсгал, зан заншил, өв уламжлалыг хамгаалах зорилготой соёлын өвийн менежмент, үйл ажиллагаандаа мөрдөх зарчим, дүрэм журмууд хийгээд орон нутгийн түүх, соёлын өвийг хадгалах, хамгаалах, чиглэлээр хэрэгжүүлж буй хамтын ажиллагааны талаарх мэдээ, мэдээллийг ажилчдад хүргэсэн болно.
ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ 2022 ОНЫ БИЕЛЭЛТ			100%	

4.6. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт

Бид Жонш байжуулах үйлдвэрийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа химийн бодис материалуудын худалдан авалт, тээвэрлэлт хадгалалт, ашиглалт болон устгал зэргийг Монгол улсын зохих стандарт, журамд нийцүүлэн боловсруулсан компанийн дотоод журмын дагуу гүйцэтгэнэ. Байгаль орчин болон баяжуулах үйлдвэрийн хэлтэс нь уурхайд ашиглагдаж буй химийн бодис материалын тээвэрлэлт, хадгалалт ашиглалт, түүний хаягдал сав баглаа боодлын устгалд хяналт тавьж аливаа үүсэж болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор төлөвлөгөөг боловсруулан ажиллаж түүний дагуу тавигдах шаардлагуудыг биелүүлэн ажиллаж байна.

Бид Байгаль орчин, Аялал Жуулчлалын яамнаас Химийн хорт болон аюултай бодис экспортлох, импортлох, хил дамнуулан тээвэрлэх, үйлдвэрлэх, ашиглах, худалдах, устгах аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөлтэй компанитай гэрээ байгуулан хамтран ажиллаж байна.

Хүснэгт 6. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Биелэлт	Тайлбар
1		Химийн бодисыг тухайн бодисын ХАЛМ-д заасны дагуу хадгалах, химийн бодис асгарсан, онцгой үед хэрэглэх багц, шингээгч материалыг шаардлагатай газруудад байрлуулах	100%	Химийн бодисыг тухайн бодисын холбогдох дүрэм, журмын дагуу хадгалж, химийн бодис асгарсан, онцгой үед хэрэглэх багц, шингээгч материалыг зохих газруудад байрлуулан ажиллаж байна.
2	Химийн бодисын асгаралт, эрсдэл шатах тослох материалын асгаралт	Химийн бодисын хор аюулын лавлах мэдээллийг үндэслэн аюулгүй ажиллагааны зааварчилгааг шинэчилж боловсруулан, өдөр тутмын үйл ажиллагаанд мөрдөж ажиллах	100%	МУ-ын холбогдох хууль эрхзүйн зохицуулалтын дагуу химийн бодисын аюулгүй ажиллагааг хангах зорилгоор холбогдох журмыг боловсруулан үйлдвэрлэлд мөрдөн ажиллаж байна. Химийн хорт болон аюултай бодисыг түүний онцлог шинж чанарыг нь харгалзан зориулалтын тусгай агуулахад, журмын дагуу хадгалж химийн хорт болон аюултай бодисын сав баглаа боодлыг тухайн бодисын нэр, анхааруулах тэмдэг, аюулыг шинж чанарыг тод, томруун бичсэн хаяг шошготой байлгах, мөн агуулахад хадгалж буй химийн бодисын хор, аюулын шинж чанараас хамааруулан зохих анхааруулах тэмдэг, дохио үг, аюулын тухай тэмдэглэгээг агуулахын гадна болон дотор харагдахуйц байрлалд тодоор байрлуулсан
3		Химийн бодисын агуулахад үерийн хамгаалалтын далан хийх	100%	Химийн бодисын агуулахыг тойруулан үерийн хамгаалалтын далан татсан.



*Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний
2022 оны хэрэгжилтийн тайлан*

4		Шатах тослох материалын болон хаягдлын түр цэгийг хөрс бохирдохоос хамгаалж бэлтгэх, асгаралтын иж бүрдлийг бэлэн байлгах	100%	Тос тосолгоо хийх үед хөрсний бохирдолоос урьдчилан сэргийлж зориулалтын зассан талбайд тос тосолгоог хийдэг ба хөрсөнд шатах тослох материал алдагдахаас сэргийлж гэмтэл, эвдрэлтэй машин техникийг ажлын талбайд гаргахгүй байх зарчмыг баримталсан. Ашиглагдсан шатах тослох материал болон химийн бодисын сав, баглаа боодлыг түр аюулгүй нөхцөлийг бүрдүүлсэн орчинд хадгалж, Химийн бодисын ашиглалт зарцуулалтын мэдээг БОАЖЯ-д тайлагнадаг.
5		Химийн бодисыг хор аюулын лавлах мэдээлэлд заасан нөхцөлд, зориулалтын тээврийн хэрэгслээр тээвэрлүүлэх	100%	Хор аюулын лавлах мэдээлэлд заасны дагуу химийн бодисыг зориулалтын тээврийн хэрэгслээр тээвэрлэдэг.
6	Гал түймэр	Галын аюулаас хамгаалах багаж хэрэгслийн бэлэн байдлыг хангаж байнга сэлбэх	100%	- Үйлдвэрийн талбайд гал түймэр, онцгой байдалд эрсдэлийг бууруулах чиглэлээр ажлын талбайд тогтмол ажлын байрны үзлэгүүд зохион байгуулж, бүх барилга байгууламжийг гал унтраах, утаа мэдрэгч тоног төхөөрөмжүүдийг бүрэн суурилуулсан. /зураг-14/ Гал түймэртэй тэмцэх болон Гамшгийн тухай хуулийн дагуу үйлдвэрийн талбайн барилга эрсдэлийн үнэлгээ, бүх хэсэг нэгжүүдэд онцгой байдлын үед ажиллах төлөвлөгөөг боловсруулан мөрдөн ажиллаж байна.
7	Хаягдлын сангийн далан нурах сэтрэх	Хаягдлын сангийн тогтворжилтыг тогтмол хянах	100%	Хүдрийн хаягдал, усан байгууламжийн менежмент” стандарт болон МУ-ын холбогдох хууль эрхзүйн зохицуулалтын дагуу үйлдвэрийн хаягдал хадгалах байгууламжийн тогтворжилт, аюулгүй байдлыг хамгаалах зорилгоор холбогдох журмыг боловсруулан үйлдвэрийн талбайд мөрдөн ажиллаж байна.
8	Биологийн эрсдэл /Covid-19/	Ариутгал, халдваргүйжүүлэлтийг хийх	100%	- Ажилчдын эрүүл мэндэд хяналт тавих шаардлагатай тохиолдолд гуравдагч эмнэлэг рүү шилжүүлэх ажлыг зохион байгуулж байна. - Цар тахлаас сум орон нутгийн иргэдийн эрүүл мэндийг сахин хамгаалахад Сумын Онцгой комисстой хамтран ажиллаж 117.0 сая төгрөгийн буцалтгүй тусламж үзүүлсэн. Үүнд: - Хүчил төрөгчийн аппарат-1 ш - Тусгай хувцас /coverall/ -100 ш - Түргэвчилсэн оношлуур-5,000 ш - Амны хаалт-5400 ш Эмнэлгийн бээлий-2000 ш
ОСОЛ ЭРСДЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ 2022 ОНЫ БИЕЛЭЛТ			100%	



Зураг 14. Гал унтраах иж бүрдэл, галын мэдрэгч байрлуулсан байдал

Үйлдвэрт ашигласан химийн бодисуудын сав баглаа боодлыг АХХ-ын журмын дагуу устгалд оруулахаар Аюултай хог хаягдал устгах тусгай зөвшөөрөл бүхий “Цэцүүх” ХХК-тай Аюултай хог хаягдал шилжүүлэх гэрээ байгуулсан.



Зураг 15. Аюултай хог хаягдлын сав баглааг нийлүүлэх гэрээ

Химийн хорт болон аюултай бодисыг түүний онцлог шинж чанарыг нь харгалзан зориулалтын тусгай агуулахад, эрх бүхий байгууллагын баталсан журмын дагуу хадгалж химийн хорт болон аюултай бодисын сав баглаа боодлыг тухайн бодисын нэр, анхааруулах тэмдэг, аюулын шинж чанарыг тод, томруун бичсэн хаяг шошготой байлгах, мөн агуулахад хадгалж буй химийн бодисын хор, аюулын шинж чанараас хамааруулан зохих анхааруулах тэмдэг, дохио үг, аюулын тухай тэмдэглэгээг агуулахын гадна болон дотор харагдахуйц байрлалд тодоор зурж, бичиж байрлуулах зэрэг анхааруулга тэмдэглэгээтэй болгосон.



Зураг 16. Химийн бодисын агуулахын гаднах болон доторхи байдал

4.7. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт

Үйлдвэрлэлийн талбайн зүүн урд хэсэгт хатуу болон ахуйн хог хаягдлын 2 цэгийг тусгаарлан байгуулж үйлдвэрээс зүүн тийш 5 км-т орших Иххэт сумын тохижилт үйлчилгээний компанитай гэрээ байгуулж хатуу хаягдлыг сард 1 удаа, ахуйн хог хаягдлыг 4 удаа ачилт хийлгэж зайлуулдаг. Ажилчдын бие засах газар, ахуйн бохир ус хуримтлуулах нүх ухаж геомембранаар доторлосон. Ахуйн бохир усыг тусгай хоолойгоор дамжуулан бохир хуримтлуулах нүхрүү шилжүүлдэг бөгөөд сард 1 удаа бохир задлагч хийж ажиллаж байна.



Зураг 17. Хог хаягдал түр хадгалах цэг




Зураг 18. Хогийн цэг, ажилчдын ариун цэврийн байгууламж

Хүснэгт 7. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Биелэлт	Тайлбар
1	Ахуйн	Хог хаягдлыг ангилан ялгаж, хог хаягдал хадгалах түр цэгийг хашаа хамгаалалт хийж, тохижуулах, хяналт тавих	100%	Хог хаягдлыг ангилж хог хаягдал хадгалах түр цэгийг хашаа хамгаалалт хийж, тохижуулсан
2		Орон нутагтай хог хаягдал нийлүүлэх гэрээ хийж тухай бүрт хүлээлгэн өгөх	100%	Холбогдох гэрээг байгуулж байнга хамтран ажилладаг.
3		Дахин ашиглах хаягдлыг дахивар авах ААНБ-тай гэрээ хийн нийлүүлэх	100%	Дахивар бүтээгдэхүүнийг түр хадгалах агуулахад хурааж нэг удаагийн нийлүүлэлтийг хийсэн байгаа
4		Сумын төвийн нэгдсэн хогийн цэгийг дарж булшлах, хог хаягдлын менежментийг сайжруулахад дэмжлэг үзүүлэх	100%	Сумын хогийн цэг дээрхи ахуйн хог хаягдлыг түрэх, бөөгнүүлэх үйл ажиллагаанд туслах ажлыг сард нэг удаа компанийн зардлаар хийж гүйцэтгэж байна.
5		Төслийн талбайн гадаад дотоод орчны цэвэрлэгээг хийж хог хаягдалгүй цэвэр орчин бүрдүүлж ажиллах	100%	Үйлдвэрээс гарч буй хог хаягдлыг төрөлжүүлэн ангилах зориулалтын сав хаягжуулан байрлуулж, нийт ажилчдад хог хаягдлын ангилан ялгалтыг хэвшүүлж ажилласан.
6	Үйлдвэрийн	Тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээний явцад гарсан хог хаягдлыг тусгайлан хадгалах, ангилж ялгах	100%	Түр хадгалах талбайд ангилж байршуулсан.
7	Аюултай	Ашиглагдсан шатах тослох материал болон химийн бодисын сав, баглаа боодлыг түр аюулгүй нөхцөлийг бүрдүүлсэн орчинд хадгалах, гэрээлэгч компанид нийлүүлж, акт үйлдэх,	100%	Цэцүүх трейд компанитай химийн бодисын хог хаягдлын гэрээ жил бүр байгуулж хамтарч ажилладаг.
8		Химийн бодисын ашиглалт зарцуулалтын мэдээ тайланг холбогдох газарт хугацаанд нь хүргүүлэх	100%	
9		Аюултай хог хаягдлын үүссэн болон хуримтлагдсан хэмжээг нэр төрөл бүрээр бүртгэл хөтлөх /хуулийн хугацаа өнгөрсөн тохиолдолд эрх бүхий байгууллагад шилжүүлэх/	100%	
ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН 2022 ОНЫ ХЭРЭГЖИЛТ			100%	

4.8. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт

Монгол Улсын Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, Ашигт малтмалын тухай хууль зэрэг хуулиудын дагуу төсөл хэрэгжүүлэгч Хөх Бишрэлт ХХК нь орчны хяналт шинжилгээний ажлын зардлыг хариуцан гаргаж, аливаа ажиглалт, хээрийн хэмжилт, дээжлэлтийг батлагдсан аргазүй, стандартын дагуу хийж, төслийн талбайгаас авсан аливаа дээжүүдийг Монгол улсад итгэмжлэгдсэн лабораториудад хүргүүлж, гарсан үр дүн, гэрээт компанийн тайланг холбогдох газруудад хүргүүлэн ажиллалаа.



Зураг 19. Орчны хяналт хэмжилтийн цэгүүдийн байршил

Хүснэгт 8. Орчны хяналт шинжилгээний цэгүүд

№	Хяналт шинжилгээ хийх төрөл	Хяналтын цэгийн байршил		Тэгш өнцөгтөөр		Газар зүйн солбицол	
				Х	У	Уртраг	Өргөрөг
1	Хөрс	1	Уурын зуухны зүүн урд	5135535.00	4252242.00	110 01 39.1169	46 22 07.6741
		2	Хөрсний овоолго	5135438.00	425185.00	110 01 36.5053	46 22 04.5092
2	Агаар	1	Хүдрийн овоолго, бутлуурын зүүн урд	5135501.00	425254.00	110 01 39.6981	46 22 06.5775
		2	Уурын зуухны зүүн урд	5135434.00	425205.00	110 01 37.4436	46 22 04.3876
		3	Автомашин утаа				
3	Ус	1	Гүний худаг	5135371.00	425193.00	110 01 36.9183	46 22 02.3420
		2	Эргэлтийн усны сан	5135246.00	425309.00	110 01 42.4186	46 21 58.3389

4.8.1. Агаарын тоосны хяналт шинжилгээ биелэлт

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд жил бүр төслийн үйл ажиллагаа явагддаг байгууламжуудын орчим болон технологийн зам дагуу агаар дахь PM10, PM2.5 тоосны түвшин, хүхрийн давхар исэл-SO2, азотын давхар исэл-NO2, нүүрсхүчлийн хий-CO, автомашины утаанд CO, CO2, CH тодорхойлоход мэргэжлийн байгууллагаар хэмжүүлж, дүн шинжилгээ хийлгэдэг. Үйлдвэрийн талбай орчимд хяналт шинжилгээний цэгүүдийг сонгохдоо салхины зонхилох чиглэл болон нөлөөллийн түвшнийг чухалчлан үзэж цэгүүдийг сонгосон. /Зураг.20./



Зураг 20. Агаарын хэмжилт

4.8.2. Хөрсний хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт

Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд хөрсний хяналт шинжилгээг явуулсан. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт заасны дагуу хаягдлын далан, хүдрийн овоолго дээр нийт 3 цэгт газар зүйн солбилцлыг тогтоон, хөрсөнд 10 см гүнтэй малталт хийж дээж авч шинжилгээнд явуулав.

Хяналт шинжилгээний үр дүнд хөрсний хүнд металлын агууламжууд MNS 5850:2019 “Хөрсний чанар. Хөрсөнд агуулагдах бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх хэмжээ” стандарттай харьцуулан үзэхэд зөвшөөрөгдөх хэмжээнд байна / Зураг.21/.



Зураг 21. Хөрсний дээж авалт

4.8.3. Усны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт

Усны чанарын хяналт-шинжилгээний хөтөлбөрийн дагуу хяналт-шинжилгээний 2 цэгээс сорьц авч, усны химийн найрлага, чанарын үзүүлэлтүүдийг Улаанбаатарт байрлах ТӨҮГ-ын итгэмжлэгдсэн “Геологийн төв лаборатори”-д шинжлүүллээ. /Лабораторийн шинжилгээг хавсралтад оруулав./

Шинжилгээний хариуг хүснэгтээр үзүүлэхдээ “MNS 0900:2018. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ” ундны усны стандартанд заасан үзүүлэлттэй харьцуулав.

Тус стандартад зааснаар эрдэсжилт буюу Нийт Ууссан Хатуу Нэгдлийн (НУХН) зөвшөөрөгдөх дээд хэмжээ 1000 мг/л байдаг. Гүний усны цооногуудын усны эрдэсжилт зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс доогуур үзүүлэлттэй байна. Иймээс тус ус нь дунд зэргийн эрдэсжилттэй, зөөлөвтөр ус байгаа бөгөөд ундны ус болон үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглахад тохиромжтой байна.

Хаягдлын усан сангийн байгууламж нь батлагдсан усны барилга байгууламжийн зураг төслийн дагуу геомембран хулдаасаар хучигдсан талбайд байрладаг учир тус талбайн газрын доорхи ус хур тунадасны уснаас шууд хамаарах хамаарал бага байгаа буюу шинжилгээгээр харьцангуй ихэвтэр эрдэсжилттэй, хатуу ус байна.

Бид цаашид мониторингийн судалгааг жил тутамд үргэлжлүүлэн хийж ажиллахаар төлөвлөж байна.

Агаар, хөрс, усны шинжилгээг үндэслэн дараах дүгнэлтийг гаргав.

4.8.4. Орчны хяналт шинжилгээний арга хэмжээний дүгнэлт:

1. Агаарын дээж авч, Байгаль орчин, хэмжилзүйн төв лабораторид хүхэрлэг хий, азотын давхар исэл, нийт тоосны агууламжийг тодорхойлсон. Шинжилгээний дүнгээс харахад MNS 4585:2016. Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага стандартад заасан стандартын зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтрээгүй байна.

Мөн өдөр дуу чимээний хэмжилт хийж үзэхэд овоолго, бутлуурын орчимд 78 ДБа, үйлдвэрийн дотор талбайд 87 ДБа, уурын зуухны орчим 65 ДБа, дугуйт ачигчийн ойролцоо 84 ДБа байсан. MNS 4585:2016 стандартад өдрийн цагаар буюу 07-22 цагийн хооронд 16 цагийн хэмжилтийн дундаж нь 60ДБа-аас хэтрэхгүй байхаар заасан байдаг. Дуу чимээний хэмжилтийг 20 минут үргэлжих хугацаанд хийсэн тул гарсан дүнг MNS 4585:2016 стандартад харьцуулах боломжгүй юм.

2. Хөрсний дээж авч дээж дэх Li, Be, Cr*, Co, Ni, Rb, Sr, Y*, Zr*, Mo, Cd, Sn*, Sb, Cs, Ba, La, Ce, Yb, W*, Pb, Bi, Th, U, As, Cu, Mn, Ti, V, Zn, Fe,% элементийн агууламжийг Геологийн төв лабораторид шинжлүүлсэн. Шинжилгээний дүнгээс харахад дээрх элементийн агууламж MNS 5850:2008 стандартад заасан зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтрээгүй байна.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн ажлын хүрээнд гүний худаг болон хаягдлын далангаас дээж авч Геологийн төв лабораторид шинжлүүлсэн. Шинжилгээний дүнд тулгуурлан химийн бүрэлдэхүүнээрээ сульфатын ангийн, холимог бүлгийн, рН 7.24 /цэвэр усанд/, 7.56 /далангийн эргэлтийн усанд/, хатуулаг 10.29 /цэвэр усанд/, 8.72 /далангийн эргэлтийн усанд/, бага зэрэг булингартай, органик гаралтай бохирдолтой ус MNS900:2018. Ундны усны чанарын стандартын шаардлага хангасан. Стандартад зааснаар эрдэсжилт буюу нийт Ууссан Хатуу Нэгдлийн (НУХН) зөвшөөрөгдөх дээд хэмжээ 1000 мг/л байдаг. Гүний усны цооногуудын усны эрдэсжилт зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс доогуур үзүүлэлттэй байна. Иймээс тус дунд зэргийн эрдэсжилттэй, зөөлөвтөр гүний усыг ундны усны ба үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглахад тохиромжтой байна.

Цаашид гадаргын болон газрын доорх усанд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахад чиглэгдсэн ажлууд, агаар, хөрсний хяналт шинжилгээний ажлуудыг жил бүрийн БОМТ-д тусгаж хэрэгжүүлэх хэрэгтэй гэсэн дүгнэлтийг гаргаж байна.



4.9. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт

4.9.1. Ус ашиглах гэрээ, дүгнэлт



Монгол улсын “Усны тухай” хуулийн 28.4, 28.6, 28.9, 28.11, 29.1, 29.2-р зүйлд заасны дагуу Умард говийн гүвээт-Халхын дундад талын сав газрын захиргаатай ус ашиглах гэрээ байгуулж жил болгон гүйцэтгэлийг дүгнүүлж, дараа жилийнхээ гэрээг байгуулж ажилладаг.

Хүснэгт 9. 2022 оны ус ашиглалтын хэмжээ /10-р сарын 01-ний байдлаар/


Д/д	Гүйцэтгэл (2022 оны 10-р сарын 01-ний байдлаар)
1	Усны тоолуурын заалтаар энэ онд нийт 12.144 м ³ /жил усыг уурхайн унд ахуй, баяжуулах үйлдвэрийн хэрэгцээнд гүний худгуудаас авч ашигласан бөгөөд ус ашигласны төлбөрт нийт 6,109,600 төгрөг төлсөн байна. <ul style="list-style-type: none"> • Хүн амын унд ахуйд ашигласан ус 684м³/жил • Баяжуулах үйлдвэрт ашигласан ус 10500 м³/жил • Зам талбайн тоосжилт дарахад ашигласан ус 960м³/жил



Зураг 22. Ус ашиглах гэрээ



Зураг 23. Ус ашиглуулах дүгнэлт



Зураг 24. Ус ашиглуулах зөвшөөрөл

Хүснэгт 10. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт

№	Авах арга хэмжээ	Биелэлт	Тайлбар
1	Мэргэжлийн байгууллагатай хамтран нийт ажилчдад хөдөлмөр хамгаалал, байгаль орчныг хамгаалах, гал түймрээс урьдчилсан сэргийлэх талаар сургалт, сурталчилгааг хийх ажлыг зохион байгуулах	100%	ХАБЭМ төвийн ХАБЭА-н ажилтны мэргэшүүлэх сургалтанд нэг ажилтнаа хамруулж сургасан. Дотооддоо ХАБЭАБО-ны чиглэлээр 2 удаагийн сургалт зохион байгуулж давхардсан тоогоор 83 ажилтныг хамруулсан.
